



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/364

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тархины саатай хүүхдүүд болон тэдний асран хамгаалагч нар болон эцэг эхчүүдэд хоёрдогч хүндрэл үүсэхээс сэргийлэх чиглэлээр хооллох, биеийн тэнцвэр суух чадварыг сайжруулах, мөлхүүлж, зогсоож сургах, туслах хэрэгсэл, хөдөлгөөн засал эмчилгээг заах вакуумжуулсан 3 хоногийн сургалтын зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах зардал 2646000/ Хоёр сая зургаан зуун дөчин зургаан мянган/ төгрөгийг Томуу томуу төст өвчинтэй тэмцэх зардал, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийг сургах, сургалт, ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал"-аас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н. Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 28-ны өдрийн
А/364 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДҮҮД БОЛОН ТЭДНИЙ ГЭР БҮЛД ЗӨВӨЛГӨӨ ӨГӨХ,
СУРГАЛТ ЯВУУЛАХ, ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭГ ЗААХ ВАКУУМЖУУЛСАН
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Өдөр	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Сургалт хийсэн хүний урамшуулал	3	1	30000	90000
2.	Хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг хооллох арга зүй, дадлага сургасан хүний урамшуулал	1	2	25 000	50000
3.	Дадлага, гардан үйлдэл хийж заасан сургагчийн урамшуулал	10	3	25000	750000
4.	Сургалтанд оролцогчдийн цай, гарын бэлэг/ХБХ-эд/	30	3	4000	360000
5.	Сургагч багшийн үдийн хоол цайны зардал	14	3	3000	126000
6.	Дасгал хөдөлгөөн, иллэг хийх хэрэгсэл/Иллэгийн тос, салфетик, гарын шингэн саван, дэвсгэр, алчуур/		3		100000
7.	Эцэг, эх асран хамгаалагчийн унааны зардал	30	3	3000	270000
8.	Хүүхдийг сайжруулах байрлалд байхад туслах, чадварыг хөгжүүлэх, хооллох болон өөртөө үйлчлэх чадварыг хөгжүүлэх сургалтын материал боловсруулах, хэвлүүлэх болон бичиг хэргийн зардал/5 төрөл/	500		1500	750000
9	ХБХ-эд туслах хэрэгсэл хийж өгөх зардал /зөөлөн дэр, ивүүр, тохойвч, өвдөгвч гэх мэт/				150000
	Нийт зардал				2646000